

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар

Сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолын хавсралт

“Баянтээг” ХК-ийн 2014 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан

I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

“Баянтээг Хувьцаат Компани”

Хаяг: Өвөрхангай аймаг, Нарийнтээл сум, Баянтээг баг

Утас: 98320010

Факс:

Электрон хаяг: Bntg_mining@yahoo.com

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 1010001008

Регистрын дугаар: 2014491

Үйл ажиллагааны чиглэл: Чулуун нүүрс олборлолт, борлуулах

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 253

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Баруун бүсийн аймгуудыг өндөр илчлэгтэй, чанартай эрчим хүчний нүүрсээр тогтмол хангах. Энэхүү ажлын хүрээнд “Баянтээг” ХК нь 2013 онд уурхайн нүүрсийг Уул уурхайн хүрээлэнгийн лаборатори болон олон улсын итгэмжлэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай 2 компаниар нүүрсний шинжилгээг хийлгүүлсэн бөгөөд нүүрсний илчлэгийг 5,500-7,000ккал илчлэгтэй гэж 2013 онд тодорхойлж байсан.

Энэ нь “Баянтээг” ХК-ийн нүүрс нь илчлэг өндөртэй, зах зээл дээр өрсөлдөхүйц эрчим хүчний нүүрс болохыг тодорхойлж байгаа юм.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухай зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Баянтээгийн нүүрсний орд нь Өвөрхангай аймгийн баруун өмнө хэсэгт Нарийнтээл сумын нутагт орших бөгөөд аймгийн төвөөс 130 км, Архангай аймгаас 467 км, Баянхонгороос 100 км, Улаанбаатар хотоос 560 км зайд оршино.

1962 онд жилд 25,0 мян,тн нүүрс олборлох хүчин чадлаар байгуулагдаж, 1978 онд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулаар нөөцийг үйлдвэрлэлийн зэрэгт шилжүүлэн 29.6 сая.тн –ийн нөөцтэй гэж тогтоосон. 1995 онд Орон нутгийн өмчит “Баянтээг”ХК болсон ба ТУЗ-ын даргаар О.Батжаргал, гүйцэтгэх захиралаар Д.Мягмар ажиллаж байна.Тус уурхай нь үндсэн 3 цех тасагтай /Захиргаа аж ахуй, Үндсэн үйлдвэр, Туслах үйлдвэр /-ийн нийт 45 ажилчинтай үйл ажиллагаа явуулж байна.Байгуулагдсан цагаас хойш/50 жилийн

хугацаанд/ 5961.48 мян.м3 хөрс хуулж, 4861.7 мян.тн нүүрс олборлон борлуулаад байна. Одоогийн байдлаар Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгийн хэрэгцээнд жилд дунджаар 40.0-55.0 мян/тн нүүрс нийлүүлж байна. Тус уурхайн нь ЭКГ-5А экскаватор-1ш, Коматцу РС-220 экскаватор-1ш,Коматцу D65E бульдозер-1ш, БНХАУ-ын TEREX автосамасвол 2ш, СБВ-2М өрмийн машин-1ш,БНХАУ-ийн NORD автосамасвол 1ш, зэрэг техник тоног төхөөрөмжтэйгээр уулын ажилыг явуулж байна.

5. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Өвөрхангай аймаг		70%
2	Шунхлай групп		23%

6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Д.Мягмар	Гүйцэтгэх захирал	Дээд	
2	Л.Энх-Отгон	Ерөнхий инженер	Дээд	
3	Ю.Ариунтунгалаг	Ерөнхий санхүүч	Дээд	
4	Д.Баясгалан	Ашиглалтын инженер		
5	Ч.Ууганбаяр	ХАБЭА-н инженер	Дээд	
6	Б.Лхамсүрэн	Борлуулалтын ня-бо	Дээд	
7	Б.Энхтуяа	Дотоод хяналтын ажилтан	Дээд	
8	З.Дашзэвгэ	ТУЗ-ийн гишүүн	Дээд	
9	Ю.Батсайхан	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Gsb mining ХХК гүйцэтгэх захирал
10	Д.Энхбат	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Хаан банк салбарын захирал
11	Г.Батсүх	ТУЗ-ийн гишүүн	Дээд	ИТХ-н дарга
12	М.Нинжбадгар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Өвөр баянбүрд ХХК захирал
13	Т.Бадрахбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Арцад богд ХХК захирал
14	Д.Самданжинмэд	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Аймгийн засаг даргын орлогч
15	О.Батжаргал	ТУЗ-ийн дарга	Дээд	Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
16	Д.Нэмэхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Судалгааны төвийн ажилтан
17	Б.Баясгалан	ТУЗ-ийн гишүүн	Дээд	ШУТСИ, УУС-н захирал
18	Л.Пүрэв	ТУЗ-ийн гишүүн	Дээд	

7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Өвөрхангай аймаг		70%
2	Шунхлай групп		23%

II. ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компанийн 2012, 2013, 2014 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
Борлуулалт	1391,3	1850,2	2130,9
Борлуулалтын хөнгөлөлт	3,9	7,2	2228,3
Цэвэр борлуулалт	1406,7	1843,0	
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		1207,7	1318,8
Нийт ашиг		642,5	812,1
Үйл ажиллагааны зардал	1156,3	210,5	297,5
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	250,5		
Үйл ажиллагааны бус зардал			
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	250,5	437,9	514,6
Орлогын татварын зардал	250,0	43,8	51,5
Цэвэр ашиг /алдагдал/	225,4	394,1	463,1

Компанийн 2012, 2013, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он
Эргэлтийн хөрөнгө	853,5	1154,2	1204,9
Эргэлтийн бус хөрөнгө	939,4	1073,8	1382,1
Нийт хөрөнгийн дүн	1793,0	2228,0	2587,0
Богино хугацаат өр төлбөр	46,8	87,8	98,7
Урт хугацаат өр төлбөр	820,8	621,1	602,4
Эзэмшигчдийн өмчийн дүн	925,3	1519,0	1885,9
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	1793,0	2228,0	2587,0

Компани нь 2014 оны жилийн эцсийн байдлаар 632,5 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай байгаа ба өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.

2. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл:

№	Овог нэр	Цалин урамшуулалын хэмжээ	Хандив тусламжийн хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Д.Мягмар	1,775,000₮	-	-	-
2	Л.Энх-Отгон	1,193,000₮	-	-	-
3	Ю.Ариунтунгалаг	960,000₮	-	-	-
4	Д.Баясгалан	771,000₮	-	-	-
5	Ч.Ууганбаяр	771,000₮	-	-	-
6	Б.Лхамсүрэн	700,000₮	-	-	-
7	Б.Энхтуяа	658,000₮	-	-	-
8	Б.Мөнхтуяа	771,000₮	-	-	-
9	З.Дашзэвгэ	90,000₮ /жилд/	-	-	-
10	Ю.Батсайхан	90,000₮ /жилд/	-	-	-
11	Д.Энхбат	90,000₮ /жилд/	-	-	-
12	Г.Батсүх	90,000₮ /жилд/	-	-	-
13	М.Нинжбадгар	90,000₮ /жилд/	-	-	-
14	Т.Бадрахбаяр	90,000₮ /жилд/	-	-	-
15	Д.Самданжинмэд	90,000₮ /жилд/	-	-	-
16	О.Батжаргал	90,000₮ /жилд/	-	-	-
17	Д.Нэмэхбаяр	90,000₮ /жилд/	-	-	-
18	Б.Баясгалан	90,000₮ /жилд/	-	-	-
19	Л.Пүрэв	90,000₮ /жилд/	-	-	-

3. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

2012 онд 25,0 сая төгрөг, 2013 онд 25,0 сая төгрөг, 2014 онд 25,0 сая төгрөг.

4. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“Баянтээг” ХК нь 2014 онд “Компанийн тухай хууль”-ийн 87, 89 дгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил боловсрол	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1	З.Дашзэвгэ		Дээд	-	тийм
2	Ю.Батсайхан	Gsb mining ХХК гүйцэтгэх захирал	Дээд	-	Үгүй
3	Д.Энхбат	Хаан банкны	Дээд	-	Үгүй

		салбарын захирал			
4	Г.Батсүх	ИТХ-н дарга	Дээд	-	Тийм
5	М.Нинжбадгар	Ахлах мэргэжилтэн	Дээд	-	Тийм
6	Т.Бадрахбаяр	Өвөр баянбүрд ХХК захирал	Дээд	-	Тийм
7	Д.Самданжинмэд	Арцад богд ХХК захирал	Дээд	-	Үгүй
8	О.Батжаргал	Аймгийн засаг даргын орлогч	Дээд	-	Үгүй
9	Д.Нэмэхбаяр	Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн дарга	Дээд	-	Үгүй
10	Б.Баясгалан	Судалгааны төвийн ажилтан	Дээд	-	Үгүй
11	Л.Пүрэв	ШУТСИ, УУС-н захирал	Дээд	-	үгүй

Компани нь 2014 оны 04-р сарын 15-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2014 оны 10-р сарын 30-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг шинээр дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон:

- a. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог З.Дашзэвгэ, Г.Батсүх, М.Нинжбадгар гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Дашзэвгэ -г томилсон.
- b. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Д.Энхбат, З.Дашзэвгэ, Ю.Батсайхан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Энхбат -г томилсон.
- c. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Ю.Батсайхан, Д.Энхбат, З.Дашзэвгэ гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Энхбат-г томилсон.

2014 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 4 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 18 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 9 тогтоол, 4 тэмдэглэл гарган баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан.

Тайлангийн хугацаанд “Нэр дэвшүүлэх хороо” 2 удаа хуралдаж 4 асуудал, “Аудитын хороо” 2 удаа хуралдаж 3 асуудал, “Цалин урамшуулалын хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал тус тус хэлэлцсэн байна. ТУЗ-ийн хурлын дундаж ирц 77,2 % байсан.

ТУЗ-с гаргасан тогтоол, шийдвэр түүний биелэлтийг өөрийн компанийн цахим сайтуудаар цахим хэлбэрээр явуулж тайлагнаж ажилласан.

6. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:

“Баянтээг” ХК нь анх 1962 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутаг дахь нүүрсний ордыг түшиглэн төвийн бүсийн болон орон нутгийн нүүрсний хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдан ажиллаж эхэлснээс хойш 1978 онд дахин нарийвчилсан хайгуул хийгдэж 29,6 сая/тн нүүрсний нөөцтэй гэж тогтоосон бөгөөд одоогийн байдлаар 5 сая гаруй тн нүүрсийг олборлон борлуулсан байна.

Уурхайн анхны төслөөр тогтоогдсон хүчин чадал 25,0 мян/тн байсан бөгөөд 1978 онд өргөтгөл хийгдсэнээр 150,0 мян/тн нүүрс олборлох хүчин чадалтай болсон.

Уурхайн тосгонд аж ахуйн болон нийгмийн зориулалттай барилга байгууламжууд байгуулагдаж тодорхой дэд бүтэц бий болсноор бага сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, холбоо, банкны салбарууд, төвийн эрчим хүчний цахилгаан түгээх дэд станц зэрэг төсвийн болон хувийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Уурхай нь 1995 оны 9-р сараас Монгол улсын аж ахуй нэгжийн хуулийн дагуу “Баянтээг” ХК болон зохион байгуулагдсан бөгөөд гаргасан нийт хувьцааны 70%-ийг орон нутаг, 30%-ийг иргэд аж ахуйн нэгжүүд эзэмшдэг.

“Баянтээг” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар аймгийн засаг даргын орлогч О.Батжаргал, Гүйцэтгэх захиралаар Д.Мягмар нар ажиллаж байна.

Компани нь нийт 50 ажилтантай бөгөөд захиргаа борлуулалт, үндсэн үйлдвэр, дулаан гэсэн гурван үндсэн хэсэгтэйгэр үйл ажиллагаагаа явуулж байна.

Уурхай байгуулагдаад 53 дахь жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд баруун болон төвийн аймгуудыг түлш эрчим хүчээр хангаж ирсэн бөгөөд цаашид ч хангах болно.

Та бүхэндээ компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн тухай танилцуулъя.

Хөрс хуулалт, нүүрс борлуулалт:

Тус компани нь 2014 онд 251,0 мян/м³ хөрс хуулах, 90,0 мян/тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажиллаж хөрс хуулалт 4 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 09 хооронд хайгуулын 49, 50, 51, 52 дугаар шугмийн хооронд явагдаж 251,9 мян/м³ хөрс хуулж, хөрс хуулалтын төлөвлөгөөг 100,2% , мөн төлөвлөгөөт онд 104,8 мян/тн нүүрс олборлон борлуулалтын төлөвлөгөөг 116,44% -иар давуулан биелүүлж ажиллалаа.

2014 оны нүүрс борлуулалтын орлого 2164615,5 мян/төг-ийн, дулаан орлого 22402,7 мян/төг, бусад орлого 76817,8 нийт 2263836,0 мян/төгрөгний борлуулалт хийсэн байна.

Нийт борлуулалтын 64634,2 мян/тн нүүрс буюу 61,7% агаарын бохирдлын хуулиар хөнгөлөлтөнд хамрагдаж 40182,4 мян/тн нүүрс буюу 38,3%-нь агаарын бохирдлын татвар 40182,4 мян/төг улсын төсөвт төвлөрүүлэн төлсөн байна.

Энэ жилийн нүүрсний борлуулалт өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйл бол илчлэг сайтай өндөр чанартай нүүрс зах зээлд нийлүүлж байгаатай холбоотой.

Нүүрсний шинжилгээг уул уурхайн хүрээлэнгийн лаборатори болон олон улсын итгэмжлэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай 2 компаниар хийлгүүлсэн бөгөөд нүүрсний илчлэгийг 5500-7000 ккал/кг илчлэгтэй байгааг 2013 онд тодорхойлж байсан.

Хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэл:

2014 онд хөрөнгө оруулалтаар батлагдсан дараахи техникүүдийг аймгийн худалдан авалтын газраас нээлттэй тендер зарлан “Нега” ХХК Солонгос улсаас оруулж ирсэн Hyundai LC-520 экскаватор 579,7 сая /төгрөгөөр, “Нутгийн буян групп” ХХК-аас NORTH BENZ маркын авто машиныг 96,0 сая/төгрөгөөр, “Нутгийн буян групп” ХХК-аас HOWO-60 маркын авто машины мото, кроп 29,5 сая/төгрөгөөр, “Укасан” ХХК-аас ISUZU маркын ачааны авто машин 40,0 сая/төгрөгөөр, мотоциколь 2ш-ийг 3,0 сая/төгрөгөөр, хөгжимийн хэрэгсэл 16,8 сая/төгрөгөөр, усны насос 7,0 сая/төгрөгөөр, компьютер тоног төхөөрөмж 4,6 сая/төгрөг зэрэг 736,6 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Цалин хөлс, өр авлагын талаар:

Компани нь нийт 50 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж ажилчдын цалинг 2014 оны эхэнд 30%-иар нэмэгдүүлсэн байна.

Дансны авлага 2012 оны эцэст 261403,9 мян/төг байсан бол 2013 оны эцэст 207852,6 мян/төг, 2014 оны эцэст 51205,4 болж 156647,2 мян/төгрөгөөр буурсан байна. Дансны богино хугацаат өглөг 98703,5 мян/төг болж ААНБ-ын орлогын албан татварт 51 сая/төгрөг төлсөн байна.

2014 онд тус компани нь татвар болон төлбөр хураамжаар улсын төсөвт 220,3 сая/төгрөг, орон нутгийн төсөвт 15,2 сая/төгрөг нийт 235,5 сая /төгрөг төлсөн байна.

2013 оны үйл ажиллагааны ашгаас хувьцаа эзэмшигчдэд олгох 25,0 сая төгрөгний ноогдол ашгийг Монголын хөрөнгийн биржийн Төлбөр тооцоо хадгаламж зээлийн төвтэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн. Сүүлийн гурван жилийн ажлын үр дүнгээр аймгийн “2014 оны тэргүүний аж ахуй нэгж”-ээр шалгарсан.

2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цэвэр ашиг 463.1 сая төгрөг хүрч ашигт ажиллагаа дээшилсэн зэрэг ажлын амжилтын үндсэн нь компанийн зүгээс нүүрсний чанараа дээшлүүлэн борлуулалтын зах зээлд нэмэгдүүлж зардлыг боломжит хэмжээнд байлгах бодит хүчин чадлыг бүрэн ашиглах ажиллагсдын чадварыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангах, үр ашиггүй үйл ажиллагаа гаргахгүй байж дотоод хяналтын систем, менежментийн үр дүнтэй бодлого амжилттай хэрэгжүүлсний үр дүн гэж дүгнэж байна.

III. ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компани нь 2014 оны 04 сарын 15-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан

- b. Аудитын хорооны тайлан дүгнэлт
- c. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв
- d. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх

Компани нь 2013 оны 04 сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- c. Компанийн 2013 оны бизнес төлөвлөгөөг батлах
- d. Компанийн аудитын хорооны тайлан
- e. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- f. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- g. Ногдол ашиг тараах эсэх